

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

/Гэр бүлийн хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх тухай
хуулийн төслийн талаар/

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.²

Түүнчлэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан.

Ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан Ажлын хэсэг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсрууллаа.

1/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл нь 5 бүлэг 40 зүйлтэй.

Хуулийн төслийг дагалдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай тус тус хуулийн төсөл болон Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан.

Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан, дагалдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг доор танилцуулна.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн зарчим, хуулийн үйлчлэх хүрээг тусгасан.

Хуулийн үйлчлэх хүрээ

Тус хуулийн төслөөр гэр бүлийн хэргийг шүүх хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх, шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах асуудлыг зохицуулах бөгөөд энэ хуульд өөрөөр зааснаас бусад харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

Олон улсын туршлагаас үзвэл, 1949 онд Япон Улсад байгуулагдсан гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд **Personal Status Litigation Act** буюу Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна.³

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улс /БНСУ/-д 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох Азийн хоёр дахь гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь **Family Litigation Act** буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон.

Ийнхүү гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд тусгасан байх ба уг хуульд зохицуулаагүй харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хуулиар зохицуулдаг байдал нийтлэг ажиглагдаж байна.⁴

Иймээс Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан бие даасан Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэл болсон.

Харин тус хуулийн төсөлд гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон бөгөөд нийтлэг харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

Өв залгамжлалын хэрэг хянан шийдвэрлэхэд энэ хууль үйлчлэхгүй буюу өв залгамжлалын хэргийг ердийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.

Түүнчлэн гэр бүлийн хэргийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эвлэрүүлэн зуучлахад энэ хууль үйлчлэхгүй. Харин шүүхийн шатанд шүүгч шаардлагатай тохиолдолд талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авахдаа Эвлэрүүлэн зуучлах багаар дамжуулан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад энэ хууль үйлчлэх юм.

³ <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

⁴ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG

Хуулийн зарчим

Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим

Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим гэхчилэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4, 5, 6 дугаар зүйлд заасан зарчим хэрэгжихээс гадна хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим үйлчлэх юм.

Хоёрдугаар бүлэг Гэр бүлийн хэрэг

Тус бүлэгт дараах асуудлыг тусгалаа. Үүнд:

- Гэр бүлийн хэргийн төрөл
- Нэхэмжлэл, хүсэлт гаргах харьяалал
- Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал
- Шүүх хуралдаан явуулах
- Шүүх бүрэлдэхүүн
- Зохигч шүүх хуралдаанд оролцох

Гэр бүлийн хэргийн төрөл

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” Арван хоёрдугаар бүлгээр гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байна.

Тус хуульд “гэр бүлийн холбогдолтой хэрэг”, “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан” гэх мэт өөр өөр нэр томъёог заасан байдаг тул нэр томъёог жигдлэн “гэр бүлийн хэрэг” болгон томъёолсон.

Мөн гэр бүлийн хэрэг болох хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах, сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг гэж тодорхойлсон.

Түүнчлэн эрх зүйн ач холбогдол бүхий садан, төрлийн холбоо байгаа эсэх, бусдын асрамжинд байгаа эсэх, хүүхдийн эцэг, эхийг тогтоолгох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, эсхүл сэргээх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох үйл явдлыг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

Харин дээрх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээс бусад гэр бүлийн хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

Гэр бүлийн хэрэг гэдэгт дараах хэрэг хамаарна:

- гэрлэлттэй холбоотой маргаан;
- эцэг, эх ба хүүхдийн хоорондын харилцаанаас үүсэх маргаан;
- эцэг, эх байхтай холбоотой маргаан;
- хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой маргаан;
- тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбоотой маргаан;
- үрчлэлттэй холбоотой маргаан;
- асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой маргаан;
- хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхтэй холбоотой маргаан;
- гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой маргаан;
- гэр бүлийн холбогдолтой бусад маргаан;
- хамтран амьдрахтай холбоотой маргаан.

Япон, БНСУ-ын гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудад “гэр бүлийн хэрэг /family case/” гэдэгт гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамжийг хэнд үлдээх, дундын эд хөрөнгийг хуваах зэрэг хэргээс гадна үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, гэрлэлт хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох зэрэг олон төрлийн хэргийг хамруулдаг байна.⁵

Иймээс гэр бүлийн хэрэгт гэрлэлт цуцлалт төдийгүй одоогийн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох зэрэг дээр дурдсан олон хэргийг хамруулсан.

Ингэхдээ онцгой ажиллагааны журмаар, ердийн журмаар хянан шийдвэрлэх хэрэг гэж 2 ангилсан.

Гэм хорын асуудлыг ердийн шүүх шийдвэрлэх ч гэр бүлийн хэрэг /жишээ нь гэрлэлт цуцлалттай холбогдуулан гэм хор, нөхөн төлбөр нэхэмжилсэн/-тэй холбогдуулан гэм хор, нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргасан бол гэр бүлийн хэрэгтэй хамт шийдвэрлэхээр тусгалаа.

Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид хамаарах нэхэмжлэл, хүсэлтийг Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх-харьяалан анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээр тусгалаа.

Дээрхээс бусад нутаг дэвсгэрт хамаарах гэр бүлийн хэргийг холбогдох иргэний хэргийн анхан шатны шүүх анхан шатны журмаар энэ хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

Түүнчлэн Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1-д Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх Монгол Улсын бүх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээн дэх гэр бүл, хүүхдийн хэргийг давж заалдах

⁵ Personal Status Litigation Act Japan 2003, 2 дугаар зүйл. Family Litigation Act 2007, 2 дугаар зүйл.

журмаар хянан шийдвэрлэхээр байсныг Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид хамаарах хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхээр, бусад нутаг дэвсгэрийн хувьд тухайн нутаг дэвсгэр дэх давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэхээр УДШ-ийн саналаар өөрчлөн тусгалаа.

Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх гэр бүлийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж, Улсын дээд шүүх гэр бүлийн хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.

Нэхэмжлэл, хүсэлт гаргах харьяалал

Нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хамаарах нутаг дэвсгэрийн анхан шатны шүүх гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ч гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргах нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргаж болох эрхийн дагуу өөрийн байгаа газрын шүүхийг сонгосон бол нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүх хэргийг хянан шийдвэрлэхээр тусгав.

Мөн шүүхийн онцгой харьяаллыг тогтоосон бөгөөд уг харьяалалд багтсан бол сонгож авсан шүүхийн харьяалал гэх ойлголт яригдахгүй болно.

Шүүхийн *ex officio* оролцоо

Шүүх өөрийн санаачилгаар нөхцөл байдлыг шинжлэн судлах агуулга бүхий шүүх нотлох зарчим хэрэгжинэ.

Гадаад улсын туршлагаас үзэхэд, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны дээд эрх, ашиг сонирхол /best interest of the child/-ыг тэргүүн ээлүид хамгаалах зорилгоор гэр бүлийн нөхцөл байдлыг нарийн шалган тогтоох /fact finding/ ажиллагаа хийгддэг.

Тодруулбал, Япон, БНСУ зэрэг гэр бүлийн дагнасан шүүхтэй улсуудад, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч өөрийн санаачилгаар захирамж гарган хүүхдийн эрх, ашиг сонрхлыг тэргүүн ээлжид хамгаалах зорилгоор гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч /family investigator/-ээр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулж, үнэлгээний тайлан гаргуулах, ач холбогдол бүхий бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах зэрэг бүрэн эрхтэй байдаг.

Манай улсын хувьд гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн систем шүүхэд байхгүй бөгөөд холбогдох зохицуулалт хуульд байхгүй, түүнчлэн иргэний хэргийн шүүгч өөрөө нотлох зарчмыг хэрэгжүүлдэггүй.

Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх гол зохицуулалт нь эдгээр улсын хувьд шүүх нотлох буюу fact finding зарчим байх тул Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан энэхүү зарчмыг бодит болгох зорилгоор хуулийн төсөлд тусгалаа.

Бусад

Түүнчлэн гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг хаалттай явуулах бөгөөд хэргийг шүүгч дангаар шийдвэрлэнэ.

Зохигч шүүх хуралдаанд өөрөө оролцох нь танхимаар болон цахим хэлбэрээр гэсэн төрөлтэй байхаар, тухайлбал хилийн чанадад байгаа бол танхимаар өөрөө оролцох боломжгүй бол цахим хэлбэрээр оролцохоор тусгалаа.

Харин хэдий хилийн чанадад байгаа ч хүндэтгэн үзэх өөр шалтгаан байхгүй бол цахимаар заавал оролцох, өөр хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд л хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан оролцохоор тусгалаа.

Шүүх хуралдаан хэдийгээр хаалттай явагдах ч цахим хэлбэрээр тухайн зохигч оролцож болно гэж энэхүү цахимаар өөрөө оролцох хэлбэрийг бий болгов.

Харин тухайн цахимаар оролцож байгаа оролцогч бусдын нөлөөнд автах, хаалттай хуралдаан бусдад задрахгүй байхаас сэргийлж, цахимаар оролцох бол байгаа газраас хамааран гадаад улсад байгаа бол ДТГ, дотоодод байгаа бол байгаа газрын шүүхийн байрнаас цахимаар оролцохоор тусгав.

Гуравдугаар бүлэг Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх

Энэхүү бүлэгт одоогийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадна шүүх нотлох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмын илрэл болох гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлахыг гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчид даалгах, шинжээч үнэлгээ хийж, тайлан гаргах, шүүгч уг тайланг шийдвэр гаргахдаа харгалзан үзэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авах эрхийг бий болголоо.

Япон, БНСУ зэрэг гэр бүлийн дагнасан шүүхтэй улсуудад, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч өөрийн санаачилгаар захирамж гарган гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч /family investigator/-ээр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулж, үнэлгээний тайлан гаргуулах, ач холбогдол бүхий бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах зэрэг бүрэн эрхтэй байдаг.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч гэр бүлийн нөхцөл байдлыг нягтлан шалгаж, маргааны шалтгаан нөхцөлийг тогтоож, эвлэрэх боломжтой эсэх, боломжтой бол эвлэрэх арга замыг санал болгох зэргээр шүүгч шийдвэрээ гаргахад шаардлагатай нөхцөл байдлыг тал талаас нь судална.

Энэхүү гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь шүүхийн ажилтан байх бөгөөд аль ч талд орохгүй, хараат бусаар, асуудлыг тал бүрээс нь судлах үүрэгтэй бөгөөд хуульч бус, нийгмийн ухаан, сэтгэл зүй, боловсрол зэрэг чиглэлийн магистрын зэрэгтэй байх шаардлага тавигддаг.⁶

⁶ IDLO зөвлөх Hyoung-ryul, KIM Presiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж 2025.

Мөн энэхүү гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээний тайланг бүх хэрэгт заавал шаардахгүй, шүүгч шаардлагатай тохиолдолд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор энэхүү ажиллагааг явуулах эрхтэй байхаар тусгалаа.

Япон, БНСУ-ын хувьд, энэхүү шинжээчийн үнэлгээний тайланг гаргуулах, холбогдох байгууллагаас шаардлагатай лавлагаа, тодорхойлолт гаргуулах нь шүүгчийн duty буюу үүрэг бус, power буюу бүрэн эрх байдаг.

Түүнчлэн энэхүү шинжээчийн үнэлгээний тайлан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шинжээчийн 47 дугаар зүйлд заасан шинжээчийн дүгнэлтээс ялгаатай буюу талууд дахин, нэмэлт шинжилгээ хийлгэх, шинжээчийн үнэлгээний тайланд гомдол гаргах эрхгүй болно. Өөрөөр хэлбэл, энэхүү гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээний тайланд Шүүх шинжилгээний тухай хуульд заасан журам үйлчлэхгүй.

Дөрөвдүгээр бүлэг Шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Гэр бүлийн хэрэг үүсгэсэн шүүгч шаардлагатай гэж үзвэл, эсхүл гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээгээр талуудыг эвлэрүүлэх боломжтой гэж үзсэн бол талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авахаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, эвлэрүүлэн зуучлалын багт хэргийг шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гаргаснаар шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэхээр тусгалаа.

Шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлалын багт хэргийг шилжүүлэхэд гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийлгэсэн бол энэ тухай шинжээчийн тайланг хавсаргаж, гэрлэгчид эвлэрэх боломж, үндэслэлийн талаарх шүүгчийн тайлбарыг энэ захирамжид тусгаж, чиглэл өгөхөөр тусгав.

Эвлэрүүлэн зуучлалын шүүгч гэх статусыг бий болгов. БНСУ-д шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлалыг эвлэрүүлэн зуучлалын баг /conciliation committee/ явуулдаг бөгөөд хороо нь эвлэрүүлэн зуучлалын шүүгч /chief mediator judge/, олон нийтээс сонгогдсон 2 эвлэрүүлэн зуучлагч гишүүнээс бүрддэг.

Эвлэрүүлэн зуучлалын шүүгч нь чиглэл өгч, хорооны бусад гишүүн эвлэрүүлэн зуучлах уулзалтыг хийж, талуудыг боломжтой бол гэр бүлийг аврах, боломжгүй бол гэрлэлт цуцлалттай холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын эд хөрөнгө хуваах асуудлаар эвийн тохиролцоог хийлгүүлдэг. БНСУ-ын Сөүл хотын Гэр бүлийн шүүхэд 40 гаруй шүүгч байдгаас шүүгчийг нь эвлэрүүлэн зуучлалын шүүгчээр томилдог байна.

Ийнхүү хуулийн төсөлд шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлах тогтолцоо, процессыг бий болгож, гэр бүлийн хэргийг үр дүнтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүллээ.

Хэрэв талууд бодит байдал дээр гэрлэлт цуцлахгүй байхаар шийдвэл шүүгч эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргахаар, харин гэрлэлтийг цуцлахаар шийдвэл эвлэрүүлэн зуучлалын баг гэрлэгчдийг гэрлэлт цуцлалттай холбоотой асуудлаар эвийн тохиролцоо хийлгүүлж, шүүгчид хүргүүлж,

шүүгч уг тохиролцоог хуульд нийцсэн гэж үзвэл гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа уг тохиролцоог тусгахаар хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалын багийн эвлэрүүлэн зуучлалын шүүгчийг шүүгчдийн зөвлөгөөнөөс томилохоор, нэг гишүүнийг олон нийтийн дундаас сонгогдсон иргэн байхаар, нэг гишүүн нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч байхаар тусгалаа.

Харин шүүхийн өмнөх урьдчилсан арга хэмжээний хүрээнд явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд энэ бүлэг хамаарахгүй буюу тус харилцааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар зохицуулна.

Тавдугаар бүлэг Бусад

Шүүхийн харьяалал, гэр бүлийн хэргийн төрлийг зохицуулсан 5, 7 дугаар зүйлийг шүүгчдийг мэргэшүүлэх, сургах зорилгоор 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, шүүхийн бэлтгэл ажил хангах зорилгоор бусад зохицуулалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгав. Ингэхдээ УДШ-ийн саналыг авав.

Мөн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө гарсан гэр бүлийн холбогдолтой хэргийг энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө уг харилцааг зохицуулж байсан хуулийн дагуу шүүх харьяалан хянан шийдвэрлэхээр тусгасан буюу 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш гаргасан гэр бүлийн хэргийн нэхэмжлэл, хүсэлтийг шинэ харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.3-д тусгасан “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөг бүрэн хангах баталгааг бүрдүүлнэ.” гэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, эрүүгийн багц хуулиуд, Хууль тогтоомжийн тухай хууль, Шүүх байгуулах тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн, Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль, ХБНГУ, ИБУМНВУ, ОХУ, БНСУ, Япон, БНХАУ, БНК улсын эрүүгийн процессын хууль болон хүүхэд холбогдсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон улсын сайн жишгийг судалж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Ингэхдээ хүүхдийн эрхийг хамгаалах талаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989 он), НҮБ-ын насанд хүрээгүй этгээдийг хорихоос зайлсхийх дүрэм (1990 он), Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам (Бээжингийн журам, 1985 он) зэрэгт заасан эрх зүйн хэм хэмжээг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хангалттай тусгасан боловч нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй, зарим зүйлийг орхигдуулсныг боловсронгуй болгож, нэмэлт, өөрчлөлтийг боловсрууллаа.

Шүүхийн харьяаллын тухайд:

Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалт, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалттай нийцүүлэн өсвөр насны хүн холбогдсон гэмт хэрэг, өсвөр насны хүнд холбогдуулан авах энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, өсвөр насны хүнийг энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасны дагуу баривчлах асуудлыг нийслэлд Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Бусад нутаг дэвсгэр дэх анхан шатны шүүх эдгээрийг нутаг дэвсгэрийн харьяаллаараа шийдвэрлэхээр тусгалаа.

Түүнчлэн арван зургаагаас арван найман нас хүртэлх хүний үйлдсэн зөрчлийн хэргийг энэхүү Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн анхан шатны тойргийн шүүх хамаарах нутаг дэвсгэрийн хүрээнд харьяалан шийдвэрлэнэ.

Өсвөр насны хүн холбогдсон гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг прокурорын саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоож болох боломжийг бий болголоо.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчил, эсхүл Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг нь үүнээс шалтгаалсан гэрлэлт цуцлуулах тухай иргэний хэрэгтэй шууд харилцан хамааралтай бол прокурор, оролцогчийн саналыг харгалзан тухайн гэмт хэрэг, эсхүл зөрчлийн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр шүүхийн харьяаллыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоож болохоор тусгасан.

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг батлан даагчийн хяналтад өгөх тухайд:

Монгол Улсын нэгд орсон Хүүхдийн эрхийн конвенцын⁷ 37 дугаар зүйлийн (а)-д “хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх” гэж заасан байдаг ч өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ тодорхойгүй, өсвөр насны хүнд хэрэглэхэд тохиромжгүй байсан.

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад итгэмжлэгдсэн этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тэднийг шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт ирүүлж байхыг хариуцах батлан даагчийн хяналтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг бий болгов.

Уг таслан сэргийлэх арга хэмжээ нь цагдан хорих таслан сэргийлэх хэмжээг хэрэглэхгүй байх, бууруулахад ач холбогдолтой. Иймд Бүгд Найрамдах Казакстан Улсын эрүүгийн процессын хуульд хуульчилсан “Насанд хүрээгүй хүүхдийг хяналтад өгөх таслан сэргийлэх арга”⁸ хэмжээг нутагшуулан тусгалаа.

Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх нийтлэг зохицуулалтын тухайд:

⁷ Монгол Улсын олон улсын гэрээ Хүүхдийн эрхийн тухай конвенц - <https://legalinfo.mn/mn/detail/1276>

⁸ УПК РК. Статья 144. Отдача несовершеннолетнего под присмотр

Олон улсын жишигт, тодруулбал Хүүдхийн эрхийн тухай конвенц, Дэлхийн эрүүгийн процессын загвар хуульд⁹ өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн мэдээллийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууцлах зохицуулалтыг өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага гэж хуульчилсан байсныг эрүүгийн процессын ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага болгон өөрчилсөн.

Мөн өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулах боломжгүй, эсхүл тийм хүн байхгүй тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр томилон оролцуулах зохицуулалтыг нэмж тусгалаа.

Уг бүлэгт өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзан хувийн мэдээллийг нууцлах, өсвөр насны хүний үйлдсэн хэргийг нэгтгэх, насанд хүрсэн хүнтэй хамтран үйлдсэн хэрэг бол хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахааргүй бол өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хэргийг тусгаарлахаар, хэрэв хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахаар байвал тусгаарлахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн газрын шүүх шийдвэрлэхээр тусгалаа.

Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай 1984 оны хуулийн¹⁰ 11D-д “Зайлшгүйгээс бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг түүний сургууль зэрэг газарт баривчилж болохгүй гэсэн олон улсын жишигт нийцүүлэн зайлшгүйгээс бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг сургууль дээр нь баривчилж болохгүй байхаар тусгав.

Өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах зохицуулалтын тухайд:

ОХУ-ын Эрүүгийн процессын хуульд¹¹ насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах ажиллагааг дэлхийн бусад улсын эрүүгийн процессын хуулиас нарийвчилсан байдлаар зохицуулсан сайн жишгийг нутагшуулахаар дараах байдлаар хуульчилсан.

Тухайлбал, Өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах эрх зүйн зохицуулалтыг хуульчлан, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн оролцоо, мэдүүлэг авах ажиллагаанд тэдний эрх, үүргийг тусгайлан тусгаж, шаардлагатай тохиолдолд сэтгэлзүйчийг оролцуулах, мөрдөгчийн зөвшөөрлөөр асуултыг зөв ойлгосон эсэхийг тодруулан асууж, тайлбарлаж болох, арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогчид тавьсан тодорхой асуулт түүний эрх ашиг, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлнө гэж тухайн мэдүүлэг авах ажиллагаанд оролцсон сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч санал гаргавал мөрдөгч тухайн асуултыг зөвхөн прокурор, шүүгчийн зөвшөөрлөөр дахин тавьж болохоор тусгалаа.

—000—

⁹ Model Code of Criminal Procedure. Vivienne O'Connor and Colette Raush editors, Pease building and Rule of law. W. 2008.

¹⁰ The Police and Criminal Evidence Act 1984

¹¹ "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 21.04.2025)